

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 12 дүгээр сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2015 оны эцэст Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 849 болж, 2014 оны эцсээс 278 хүнээр, өмнөх сарынхаас 277 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 47.35 хувь буюу 402 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхнээс 1686 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 1037 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 39.92 хувь буюу 414 нь эмэгтэйчүүд байв

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр




бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 11 дүгээр сарын эцсийн байдлаар

Тайлант сард бүртгүүлсэн 485 ажилгүй иргэний 21.65 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 18.14 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 14.85 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 12.37 хувь нь орон тооны цомхтголд орсон; 7.22 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж

орлогогүй болсон; 6.8 хувь нь шилжин суурьшсан; 3.09 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 2.68 хувь нь байгууллага татан буугдсан; 2.68 хувь нь тэтгэвэрт гарсан; 1.65 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 1.24 хувь нь цэргээс халагдсан; 0.82 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.62 хувь нь хорих газраас суллагдсан; 6.19 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 12 дүгээр сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны жилийн эцсийн мэдээгээр НДШ-ийн орлого 14.7 тэрбум ₮ болж төлөвлөгөө 90.10 хувь болж, төлөвлөгөөг 12 сум 4.2-18.19 хувиар давуулан биелүүлж, Аргалант, Архуст, Батсүмбэр, Баян, Баянжаргалан, Баянцогт, Борнуур, Жаргалант, Заамар, Лүн, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэсант, Зуунмод сумд 1.52-34.27 хувиар

тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 1.03 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 36.9 тэрбум ₮ зарцуулж, 100.0 хувь олгов. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.2 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 255480 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 39.88 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 29.84%; тэтгэмжийн даатгалын сангийн 97.04%; эрүүл мэндийн даатгалын сангийн 101.64%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 362.81%; ажилгүйдлийн даатгалын сангийн 77.01%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 50742 хүнд олгож, 14.0 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оноос үеэс хүний тоо 0.9 хувь 501 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 40.7 хувь 4.0 тэрбум ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 109030 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 50.2 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 20.3 хувийг халамжийн тэтгэвэр; 7.6 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 7.5 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.0 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 4.7 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож


байгаа хөнгөлөлт, тусламж 0.83 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



1.3 Эрүүл мэнд

2015 онд 14611 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.57 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 онд 1274 хүүхэд мэндэлсэн нь 2014 оноос 60 хүүхдээр буурлаа.



2015 онд 1 хүртэл насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оноос 5-аар буурлаа.

Эмнэлгийн мэдээгээр 2015 онд 455 хүн нас барсан нь 2014 оноос 17.6 хувиар өслөө. Нас барсан хүний 12.7 хувь буюу 58 нь эмнэлэгт нас баржээ.

Нас баралтыг шалтгаанаар аваад үзвэл хорт хавдарын нас баралт хамгийн өндөр 22.9 хувийг эзлэв.



1.4 Байгаль орчин

Төв аймгийн 2015 оны 12 сарын цаг агаарын байдлыг

анхаарна уу.

- агаарын дундаж температур 14-22 градус хүйтэн буюу ихэнх нутгаар хүйтэн, зарим газраар буюу Заамар, Дэлгэрхаан, Баянцагаан, Борнуур орчмоор хүйтний эрч арай сулавтар байв.

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 1-9 градус хүйтэн буюу Бүрэн, Дэлгэрхаанд агаарын хамгийн дулаан температур 1-2 градус хүйтэн байсан бол, Баянжаргалан орчмоор 9 градус хүйтэн байв.

-шөнийн хугацааны агаарын хамгийн бага температур нь 26-39 градус хүйтэн буюу Дэлгэрхаанд 26 градус хүйтэн, нутгийн зүүн хойд хэсэг болон Заамар орчмоор шөнөдөө агаарт 39 градус хүрч хүйтэрсэн байна.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 0,0-9,9 мм, үүнээс хамгийн их нь Батсүмбэрт 9,9 мм, Байнсандманьд 5,1 мм, Борнуурт 4,7 мм, Угтаалд 4,3 мм, бусад нутгаар 0,0-3,4 мм цас оржээ.

-салхины их хурд нийт нутгаар 4-12 м/с, зарим газраар түр зуур 14 м/с хүрлээ.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

2015 оны 12-р сард нутгийн зүүн хойд хэсэг болон зарим газраар 2014 оныхоос бага орсон байгаа боловч, зарим нутгаар ахиу орж, нийт нутгаар 2-15 см зузаан цасан бүрхүүлтэй байгаа нь 2014 оны 12 сараас цасан бүрхүүлийн хувьд илүү байна.

Цаг агаарын үзүүлэлтүүдийг 2014 оны 12-р сартай харьцуулахад:

- агаарын дундаж температур ихэнх нутгаар ойролцоо

-өдрийн хамгийн их температур ихэнх нутгаар ойролцоо буюу зарим газраар хүйтэн хүйтэн ажиглагдсан

-харин шөнийн хамгийн бага температур Дэлгэрхаан, Баянчандманаас бусад нутгаар 1-14 градусаар хүйтэн ажиглагдсан

-сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд өмнөх оны 12-р сараас нутгийн зүүн хойд талын сумд болон зарим газраар бага, бусад нутгаар ахиу оржээ.

Цаашид цас их орж, цасны зузаан улам нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлөхөөр байна. Мөн үе үе хүчтэй цасан шуурга шуурч, малын хариулга маллагаа болон зам тээврийн ажилд хүндрэл учруулж болзошгүйг онцгой

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монголын орны нутгаар 1 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын температур ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим ба түүнээс дулаан, нутгийн зүүн өмнөд хэсгээр дунджаас хүйтэн, цас ихэнх нутагт дунджийн орчим ба Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг болон нутгийн зүүн өмнөд хэсэгт дунджаас ахиу орохоор байна.

2016 ХОЁР ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Агаарын температурын сарын дундаж нь голын сав нутгаар 21-26, бусад нутгаар 15-20 градус хүйтэн буюу олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард ихэнх нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй.

Аюулт үзэгдэл

Аюулт үзэгдэл, осол 2015 онд 93 удаа гарсны улмаас 111 хүн амь насаа алдаж, 37144 толгой мал хорогдлоо. Энэ онд объектын түймэр 45 удаа, шатсан гэр, орон сууц 29 удаа бүртгэгдлээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2015 онд 5812.1 сая ₮-ийн хохирол учирлаа.



1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 онд аймгийн хэмжээнд 863 гэмт хэрэг бүртгэгдэж 884 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 3.0 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.

Гарсан гэмт хэргийн 45.8 хувь нь хулгай, 27.8 хувь нь иргэний эрүүл мэнд

эрх чөлөөний хэрэг, 14.3 хувь нь замын осол, 3.8 хувь нь танхай дээрэм, 1.0 хувь нь хүн амины хэрэг, 7.2 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Аргалант, Баян, Баяндэлгэр, Заамар сумд 10000 хүнд 762-202 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (143 харьцангуй их байна. Гэмт хэргийн тоо 2014 оноос 92 хэргээр буурлаа.


Зуунмод суманд 43 эмэгтэй, 1108 эрэгтэй нийт 1151 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оноос 4 хүнээр буурлаа. 432 хүн баривчлагдлаа



Гарсан гэмт хэргийн 5.9 хувь нь бүлгээр; 20.9 хувь нь согтуугаар үйлдэгджээ.


Гэмт хэргийн улмаас 367 хүн гэмтэж, 66 хүн нас барлаа.

10000 хүнд ногдож гэмт хэргийн тоог газрын зургаар харуулвал.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 онд ажиллагаа хийгдэж байгаа 816 гүйцэтгэх хуудсанд нийт 3.43 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 140 гүйцэтгэх хуудсанд ногдох 1.05 тэрбум ₮-ийн материалд байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 676 гүйцэтгэх хуудасны 2.38 тэрбум ₮-өөс 478 хуудасны 1.22 тэрбум ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 70.71 хувь, үнийн дүнгээр 51.51 хувь болж 2014 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 9.74 нэгжээр өсч, үнийн дүнгийн биелэлт 21.96 нэгжээр буурлаа.



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2015 онд кассын орлого 409.9 тэрбум ₮, кассын зарлага 407.8 тэрбум ₮ болж, гүйлгээнд 1.5 тэрбум ₮ байна. ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 2015 оны байдлаар 114.7 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 3.4 сая ₮-өөр буурлаа.

2015 он гарсаар бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 119.2 тэрбум төгрөгийн зээл олгожээ.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 онд орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 13.0 тэрбум ₮, зарлага 63.3 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 101.42 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Улсын тэмдэгтийн хураамж, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, татварын бус орлого, хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.



Аймгийн төсвийн орлого 2014 оноос 1.4 хувь буюу 181.4 сая ₮-өөр өслөө. Аймгийн

төсвийн орлогын 86.2 хувийг татварын, 12.5 хувийг татварын бус, 1.2 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2014 оноос татварын орлого 2.4 нэгжээр өч, татварын бус орлого 3.2 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 0.8 нэгжээр өслөө.

Аймгийн нийт 3 шатны орлого 17.1 тэрбум ₮ болж аймгийнх 10.6 тэрбум ₮ буюу 62.23 хувь, сумынх 2.4 тэрбум ₮ буюу 14.04 хувь, улсынх 4.0 тэрбум ₮ буюу 23.73 хувийг тус бүр бүрдүүлжээ



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

а.Аймгийн төвд 2015 оны 12 дугаар сард хэрэглээний үнийн индекс суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 60.89%, өмнөх оны мөн үеэс 6.12%-аар тус тус өсч, өмнөх сараас 0.03 хувиар буурав.

Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эхнээс, хувиар



Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 12 дугаар сарын 0.03 хувийн бууралтад хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн 0.08 нэгжийн бууралт; орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн 0.06 нэгжийн бууралт; мөн хувцас, бөс барааны бүлгийн 0.1 нэгжийн өсөлт голлох нөлөө үзүүлэв.

Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 11 дүгээр сарын 1.31 хувийн өсөлтийн 0.71 нэгж (51.69%) нь хувцас, бөс барааны бүлгийн, 0.27 нэгж (19.80%) нь тээврийн бүлгийн, 0.19 нэгж (13.50%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн, 0.18 нэгж (12.87%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн, 0.04 нэгж (2.94%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн, 0.03 нэгж (2.44%) нь амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн өсөлтөөс тус тус шалтгаалав.

Бараа, үйлчилгээний б?лэг	2015 оны 12 сард пунктээр
Б?рд	-0.03
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0.08
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00
03. ХУВЦАС, Б?С БАРАА, ГУТАЛ	0.10
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	-0.06
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.01
06. ЗМ, ТАРИА, ЗМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.01
07. ТЭЭВЭР	0.00
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
09. АМРАЛТ, Ч? Л? ? Т ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00



II.5 Аж үйлдвэр

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2015 онд (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 37.87 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оноос 59.3 хувь буюу 14.1 тэрбум ₮-өөр өслөө.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 12 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр,
сая.төг
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln togj


АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2014 XII	2015 XII	2014 I-XII	2015 I-XII	Дүнд заах % Percentage share to total		2015/ 2014%
					2014 I-XII	2015 I-XII	
Нийт дүн	1,950.28	768.59	23,770.96	37,876.83	100.0	100.0	159.3%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	1,237.39	242.54	15,746.41	31,214.21	66.24%	82.41	198.2%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	417.27	322.83	6,271.54	5,110.09	26.38	13.49	81.5%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy/steam	295.62	203.22	1,753.01	1,552.54	7.4	4.10	88.6%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, арьс шир боловсруулах,

ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, нийтлэх хэвлэх дуу бичлэг хийх үйл ажиллагаа, ариутгал, ус хангамж үйлдвэрлэл өмнөх оноос 98.2-1.2 хувь буюу 15.46 тэрбумаас -0.11 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 12 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Баянчандмань, Зуунмод, Баянцагаан, Баянцогт сумд 45.89-2.89 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 94.96) хувийг эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 11 дугаар сарын байдлаар, хувиар



II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2015 онд 9.6 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2014 онтой харьцуулахад

1.8 дахин буюу 7.3 тэрбум ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 36.61 хувь нь орон сууцны барилгад; 32.49 хувь нь инженерийн барилга байгууламжид; 30.89 хувь нь орон сууцны бус барилгад ногдож байна. Энэ нь 2014 онтой харьцуулахад орон сууцны барилгын ажил 9.52 пунктээр; орон сууцны бус барилгын ажил 9.43 пунктээр тус тус өсч; инженерийн барилга байгууламжийн ажил 18.95 пунктээр буурсан үзүүлэлт юм.




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого 2015 онд 198.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 95.3 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.26 хувь буюу 66.9 сая ₮ өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 94.0 сая ₮ болж, нийт орлогын 72.84 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 22.54 хувийг албан бичгийн, 12.61 хувийг зорчигчдын, 64.85 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 11 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2015 оны эхний 12 сарын мэдээгээр нийт 280 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 484; үүнээс тохирлын гэрчилгээ 409, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 75; цулын хэмжүүр 1182, үүнээс жин 960, туухай 207, автомашины жин 7; тунагч 8; эзлэхүүний хэмжүүр 426, үүнээс түгээгүүрийн хошуу 335, сүмбэн метр 52, усны тоолуур 20; шигэн бүтээгдэхүүн хэмжих хэрэгсэл 12, мерник 1, цахилгааны хэмжүүр 2312, үүнээс нэг фазын тоолуур 2108, гурван фазын тоолуур 204, даралтны аппарат 64 тус бүр баталгаажуулсан байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 12 сард нийт 1121 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 36; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 605; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 1; бэлэглэлийн гэрээ 9; худалдах, худалдан авах гэрээ 51; өв залгамжлал 16; барьцааны гэрээ 288; бусад бүртгэл 114 тус бүр бүртгүүлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2015 оны эхний 12 сард нийт 182 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 123; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 24; гишүүдэдээ

үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 6; Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/ 1; хоршоо 7; сан 1; төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар /ТБАГУТҮГ/ 2; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 15; банк бус санхүүгийн байгууллага 2 тус бүр бүртгүүлээ.Хуулийн этгээдийн бүртгэлийн 2015 оны 12 сарын мэдээгээр 306 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 62; гишүүн нэмэгдсэн 62; данс нэмэгдсэн 18; дүрэм шинэчилсэн 10; дахин гэрчилгээ авсан 31; удирдлага өөрчлөгдсөн 24; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 24; дүрмийн сан нэмэгдсэн 15; нэгдсэн 1; хаяг өөрчлөгдсөн 10; татан буугдсан 40; нэр өөрчлөгдсөн 8; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүлээ.